



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2019 оны 03 дугаар сарын 25 № 02/134
сэтгэсэн дагуу 2019/22/СЭХ-ТӨЧГ
Г Зөрчил арилгуулах тухай Т

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайландаа санхүүгийн тайлангийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын үйл ажиллагааны орлогыг хянан баталгаажуулах явцад Нийслэлийн газрын албатай газар эзэмших, ашиглах гэрээ байгуулаагүйн улмаас АНУ-ын ЭСЯ-ны 2018 оны газрын түрээсийн төлбөрөөс нийслэлийн төсөвт газрын төлбөрийг төлөөгүй;
2. Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын ашиглаж байгаа газрын эзэмших, ашиглах гэрээг Нийслэлийн газрын албатай байгуулаагүйгээс Газрын төлбөрийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт төлөгдөх газрын төлбөр төлөгдөхгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Монгол Улсын Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө”, Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “… газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна”, 10 дугаар зүйлийн 10.1-д “Газрын төлбөрийн орлогыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт оруулна”, мөн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д “Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.6.2-т “газрын төлбөр” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Нийслэлийн газрын албатай Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшиж ашиглаж байгаа газрын гэрээг байгуулж, газрын төлбөрийг хуульд заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх;



Актыг, албан шаардлагын билэлтэй хангагдаггүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хувацаанд нь билэглээгүй тохиолдолд зөрчия гаргасан албан тушаалтныг үүрээг ажлаас нь халах тухай санаалыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гээж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцруулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



\\\\10.10.20\\Bichig_Khereg\\Alban Shaardlaga\\2019\\0325SAG5.Docx

070533

2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын дарга /Ё.Нямжав/, дэд захирал /Д.Чулуунбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Болдбаатар/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
 Д.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР
 Л.ХОНГОРЗУЛ
УХААНДАА
УХААНДАА

ЗӨВШӨӨРСӨН:
ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫГ ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ЗАХИРАЛЫН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ
 Д.ЧУЛУУНБААТАР
ҮЙЛЧИЛГЭЭ ЗЭХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
 Б.БОЛДБААТАР
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Б.БОЛДБААТАР

Актыг, албан шаардлагын биелэлтийг хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хувьтой 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гээс заасны дагуу хариуцагч байгууллагас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг үзүүлэхийг тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг албан тушаалтанд хариуцагч тооцуулахад эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.